



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/28

Арвайхээр

Томуу, томуу төст өвчний тархалтыг бууруулах,  
шинэ коронавирусийн халдвараас урьдчилан  
сэргийлэх зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэх  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “в”, 29.1.6 “л”, “ж”, Улсын онцгой комиссын 2020 оны 01 дүгээр хурлын тэмдэглэл, Эрүүл мэндийн сайдын “Шинэ коронавирусийн халдварын болзошгүй эрсдлээс сэргийлэх, бэлэн байдлыг хангах тухай” 2020 оны 19 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Томуу, томуу төст өвчний өвчлөл, тархалт болон шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор эмнэлгийн орчноос халдвар авахаас сэргийлж зөвлөгөө өгөх дуудлагын утсыг Эрүүл мэндийн газарт ажиллуулах, яаралтай тусламжийн эмч, жолооч, автомашиныг нэмэгдүүлэх, хүн хүчний болон бусад нөөцийн бэлэн байдлыг хангах төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэхийг аймгийн Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв)-т үүрэг болгосугай.

2. Хүүхдийн амбулаторийн үзлэгийг гэрийн эргэлтэд бүрэн шилжүүлж ажиллахад зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв), Бүсийн оношилгоо, эмчилгээний төв (Э.Хүдэрчулуун), сум, өрхийн Эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Бүх шатны сургалтын байгууллагын хичээл, сургалтын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосонтой холбогдуулан олон нийтийг хамарсан урлаг, спортын нэгдсэн арга хэмжээ зохион байгуулахгүй байх, цахим тоглоомын газар, интернет кафе зэрэг бусад сургалтын үйл ажиллагааг түр хаах, сургууль, цэцэрлэгийн насны хүүхдүүдийг албан байгууллага, олон нийтийн болон үйлчилгээний газраар дагуулж явахгүй байх, энэ талаар иргэн, хуулийн этгээдэд мэдээлэх, сурталчлах, худалдаа үйлчилгээний төв зах, иргэдэд үйлчилдэг бусад худалдаа, үйлчилгээний байгууллагуудын ажиллах цагийн хуваарьт хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (О.Ганбат), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Томуу, томуу төст өвчин, шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэхэд хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгслэл, гар ариутгах, халдваргүйтгэх бодис, амны хаалт зэрэг хэрэглэгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, үнийг нэмэхгүй байхыг бүх шатны эмийн эргэлтийн сангуудад зөвлөж, үнэ нэмсэн тохиолдолд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн) нарт даалгасугай.


011100057



2.

5. Холбогдох дээд шатны байгууллагуудаас өгөгдсөн тогтоол шийдвэрүүдийн хэрэгжилтийг зохион байгуулж, тухай бүр тайлагнаж ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад, энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (О.Батжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД